



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 12

№ 01/16 ДУА 2018/87/СТА - ТЧЗ

Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Т

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад багш нарт 5 жил тутамд нэг удаа олгодог тэтгэмжийг 60 сар хүрээгүй байхад олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Боловсролын тухай хуулийн 43.1.7-д /Дараах этгээдэд 5 жил тутамд нэг удаа б сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох / заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн толбор, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн толборийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор толборийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.5-т /Байгууллагын гэрээ хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмын шаардлага нөхцлийг хангагүй/ 4.1.7-д /Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх, үр нөлөөтэй гэж узсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

- Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн төсвийн шууд захирагч Т.Туяамандах, Нягтлан бодогч С.Жалбаа нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

ӨГСӨН<sup>1</sup>:

АУДИТОР: *Д.Сүнжүйт* ТОЮУН-ЭРДЭНЭ

4817044213

ЗЮАО № 39 9033475

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ *Д.Сүнжүйт* ТУЯАМАНДАХ

НЯГТЛАН БОДОГЧ *С.Жалбаа* С.ЖАЛБАА

ЗҮЛДӨӨ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлтийг хангаждаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээвэй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцаач албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.